

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/05-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2024 он	Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

–	
1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	18-20
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20-21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22-23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗД	Засаг дарга
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ
СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Ё.БУЯНДЭЛГЭР ТАНАА

2024.02.20 № СЭА-2024/05-НА-СЭА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын бараа материалын дансанд Ковид 19 цар тахал өвчинтэй холбоотойгоор өмнөх онуудад ЭМЯ, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан нийт 147,277.1 мянган төгрөгийн эм, хамгаалах хэрэгсэл бүртгэлтэй байна. Эдгээр бараа материалын ашиглалтын хугацаа дуусаж, хадгалалтын нөхцөл алдагдаж ашиглагдахгүй болох эрсдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 175 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь

эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	496,444,177.21	748,479,253.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,750,166.63	1,006,760.09
31211	Төрийн сангийн харилцах	1,750,166.63	1,006,760.09
33	АВЛАГА	-	301,744,449.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	301,744,449.00
35	БАРАА МАТЕРИАЛ	494,694,010.58	445,728,044.01
351	Түүхий эд материал	346,168,882.93	275,325,907.74
35110	Тусгай зориулалттай материал	1,083,100.00	1,276,420.00
35130	Эм боох материал	345,085,782.93	274,049,487.74
354	Хангамжийн материал	148,525,127.65	170,402,136.27
35420	Аж ахуйн материал	81,389,850.00	80,463,845.40
35430	Сэлбэг хэрэгсэл	35,671,502.65	45,768,411.87
35440	Түлш, шатах тослох материал	-	895,000.00
35450	Барилгын засварын материал	383,000.00	646,500.00
35460	Хүнсний материал	7,222,625.00	2,623,332.00
35470	Бусад хангамжийн материал	23,858,150.00	40,005,047.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,445,260,674.61	5,683,069,150.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,445,260,674.61	5,683,069,150.31
392	Биет хөрөнгө	4,336,459,841.32	5,574,354,317.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,423,309,110.35	3,703,255,868.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(536,947,935.99)	(678,973,202.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	330,252,444.40	312,442,355.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	(228,046,194.44)	(179,479,416.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,124,975,814.77	3,376,377,817.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(881,630,351.82)	(1,098,081,325.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	164,994,434.93	188,881,558.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	(83,155,406.55)	(69,688,446.67)
39209	Зам, гүүрний байгууламж	29,917,849.95	29,917,849.95
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,779,824.28)	(10,868,640.96)
39217	Ном	569,900.00	569,900.00
393	Биет бус хөрөнгө	108,800,833.29	108,714,833.25
39301	Программ хангамж	258,000.00	258,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(93,166.71)	(179,166.75)
39303	Бусад биет бус хөрөнгө	108,636,000.00	108,636,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,941,704,851.82	6,431,548,403.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	366,589,566.08	667,124,023.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	366,589,566.08	667,124,023.17
413	Өглөг	366,589,566.08	667,124,023.17
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	93,205,513.09
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	284,192,766.08	468,384,888.08
4136	Бусад өглөг	82,396,800.00	105,533,622.00
41361	Байгууллагад төлөх өглөг	82,396,800.00	105,533,622.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,575,115,285.74	5,764,424,380.24
51	Засгийн газрын хувь оролцоо	4,575,115,285.74	5,764,424,380.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,347,393,178.65	1,347,393,178.65
51101	Өмч: - төрийн	1,347,393,178.65	1,347,393,178.65
512	Хуримтлагдсан үр дүн	471,716,550.11	1,661,025,644.61
51210	Өмнөх үеийн үр дүн	471,716,550.11	471,716,550.11
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,189,309,094.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,756,005,556.98	2,756,005,556.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,941,704,851.82	6,431,548,403.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,441,542,428.39	9,239,897,773.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	577,310,807.29	1,922,268,684.08
120	Нийтлэг татварын бус орлого	577,310,807.29	1,689,789,316.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	577,310,807.29	1,689,789,316.96
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,549,522.00	172,974,690.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,276,928.00	5,917,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	242,721,777.52	1,454,311,559.92
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	171,762,579.77	56,585,966.53
122	Тусламжийн орлого	-	232,479,367.12
122001	Хандив тусламж /дотоод/	-	232,479,367.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,864,231,621.10	7,317,629,089.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,864,231,621.10	7,317,629,089.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,864,231,621.10	7,317,629,089.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,710,309,375.60	8,050,588,678.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,710,309,375.60	8,050,588,678.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,707,299,375.60	8,045,663,678.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,260,169,100.21	4,147,154,782.77
210101	Үндсэн цалин	1,632,310,742.97	2,390,283,282.63
210102	Нэмэгдэл	1,313,022,678.41	1,380,109,823.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	111,602,993.04	113,825,811.45
210104	Урамшуулал	203,232,685.79	262,935,864.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	408,131,459.47	516,011,588.11
210201	Тэтгэврийн даатгал	264,924,239.47	356,587,988.11
210202	Тэтгэмжийн даатгал	35,801,807.00	39,855,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,641,444.00	31,884,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,160,362.00	7,971,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	71,603,607.00	79,711,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	582,117,386.00	600,055,078.49
210301	Гэрэл, цахилгаан	76,362,076.00	113,787,858.50
210302	Түлш, халаалт	325,233,900.00	371,114,917.99
210303	Цэвэр, бохир ус	180,521,410.00	115,152,302.00
2104	Хангамж, бараа материалын зардал	110,167,037.00	133,413,438.73
210401	Бичиг хэрэг	7,688,116.00	17,236,140.00
210402	Тээвэр, шатахуун	60,478,751.00	63,362,491.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,076,070.00	5,762,997.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,276,550.00	10,106,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,647,550.00	36,944,910.00
2105	Нормативт зардал	1,406,612,588.38	1,673,760,807.14
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,247,987,672.88	1,479,318,109.14
210502	Хоол, хүнс	158,624,915.50	194,442,698.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,117,720.00	90,878,320.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	4,311,000.00	36,250,300.00
210602	Тавилга	-	1,672,000.00
210604	Урсгал засвар	48,806,720.00	52,956,020.00
2107	Томилолт, зочны зардал	7,825,600.00	7,353,500.00
210702	Дотоод албан томилолт	7,825,600.00	7,353,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,062,156.00	286,974,812.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	199,682,250.00	277,862,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,218,375.00	404,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	751,695.00	1,466,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	176,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	610,936.00	6,313,700.00
210807	Газрын төлбөр	968,700.00	928,049.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,654,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	669,096,328.54	590,061,351.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,960,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	667,136,328.54	590,061,351.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,010,000.00	4,925,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,010,000.00	4,925,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,925,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,010,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(268,766,947.21)	1,189,309,094.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(268,766,947.21)	1,189,309,094.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс-ны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,363,964,588.10	7,194,776,430.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,826,450.00	178,891,790.51
120	Нийтлэг татварын бус орлого	162,826,450.00	178,891,790.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	162,826,450.00	178,891,790.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,549,522.00	172,974,690.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,276,928.00	5,917,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,201,138,138.10	7,015,884,640.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,201,138,138.10	7,015,884,640.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,201,138,138.10	7,015,884,640.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,326,678,132.68	7,054,440,937.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,326,678,132.68	7,054,440,937.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,323,668,132.68	7,049,515,937.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,472,434,302.21	4,072,328,557.79
210101	Үндсэн цалин	1,844,575,944.97	2,342,999,226.65
210102	Нэмэгдэл	1,313,022,678.41	1,380,109,823.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	111,602,993.04	113,825,811.45
210104	Урамшуулал	203,232,685.79	235,393,695.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	438,664,609.47	497,632,300.00
210201	Тэтгэврийн даатгал	295,457,389.47	338,208,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	35,801,807.00	39,855,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,641,444.00	31,884,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,160,362.00	7,971,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	71,603,607.00	79,711,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	583,067,720.00	538,033,397.48
210301	Гэрэл, цахилгаан	76,362,076.00	100,473,673.21
210302	Түлш, халаалт	325,233,900.00	329,020,971.27
210303	Цэвэр, бохир ус	181,471,744.00	108,538,753.00
2104	Хангамж, бараа материалын зардал	109,041,550.00	134,041,575.73
210401	Бичиг хэрэг	7,688,116.00	13,269,620.00
210402	Тээвэр, шатахуун	59,353,264.00	65,470,978.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,076,070.00	5,762,997.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,276,550.00	5,365,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,647,550.00	44,172,980.00
2105	Нормативт зардал	1,520,868,345.00	1,462,687,769.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,367,873,570.00	1,259,107,614.05
210502	Хоол, хүнс	146,845,575.00	189,668,155.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,149,200.00	13,912,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,081,100.00	58,662,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,658,300.00	8,173,000.00
210604	Урсгал засвар	48,422,800.00	50,489,150.00
2107	Томилолт, зочны зардал	6,481,200.00	6,515,800.00
210702	Дотоод албан томилолт	6,481,200.00	6,515,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	134,069,306.00	279,614,387.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	122,864,400.00	269,407,750.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,218,375.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	751,695.00	1,466,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	176,000.00	-

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,435,936.00	5,357,000.00
210807	Газрын төлбөр	968,700.00	928,049.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,654,200.00	2,455,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,960,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,960,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,010,000.00	4,925,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,010,000.00	4,925,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,925,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,010,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	37,286,455.42	140,335,493.46
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	38,075,300.00	141,078,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,075,300.00	141,078,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	38,075,300.00	141,078,900.00
223001	Бусад хөрөнгө	38,075,300.00	141,078,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(38,075,300.00)	(141,078,900.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(788,844.58)	(743,406.54)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,750,166.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,750,166.63	1,006,760.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	471,716,550.11	4,575,115,285.74
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	471,716,550.11	4,575,115,285.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	471,716,550.11	4,575,115,285.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,189,309,094.50	1,189,309,094.50
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,756,005,556.98	1,661,025,644.61	5,764,424,380.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,278,964,400.00	7,195,519,837.05	1,089,943,562.95	86.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,278,964,400.00	7,054,440,937.05	1,231,022,462.95	85.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,278,963,400.00	7,049,515,937.05	1,229,447,462.95	85.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,076,179,700.00	4,072,328,557.79	3,851,142.21	99.91
210101	Үндсэн цалин	2,331,955,200.00	2,342,999,226.65	(11,044,026.65)	100.47
210102	Нэмэгдэл	1,339,219,100.00	1,380,109,823.81	(40,890,723.81)	103.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	159,726,900.00	113,825,811.45	45,901,088.55	71.26
210104	Урамшуулал	245,278,500.00	235,393,695.88	9,884,804.12	95.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	497,632,300.00	497,632,300.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	338,208,700.00	338,208,700.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	39,855,900.00	39,855,900.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,884,700.00	31,884,700.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,971,200.00	7,971,200.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	79,711,800.00	79,711,800.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	751,565,400.00	538,033,397.48	213,532,002.52	71.59
210301	Гэрэл, цахилгаан	81,599,900.00	100,473,673.21	(18,873,773.21)	123.13
210302	Түлш, халаалт	510,809,800.00	329,020,971.27	181,788,828.73	64.41
210303	Цэвэр, бохир ус	159,155,700.00	108,538,753.00	50,616,947.00	68.20
2104	Хангамж, бараа материалын зардал	211,247,800.00	134,041,575.73	77,206,224.27	63.45
210401	Бичиг хэрэг	12,650,000.00	13,269,620.00	(619,620.00)	104.90
210402	Тээвэр, шатахуун	82,798,600.00	65,470,978.00	17,327,622.00	79.07
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,944,000.00	5,762,997.73	(1,818,997.73)	146.12
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	66,855,200.00	5,365,000.00	61,490,200.00	8.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,000,000.00	44,172,980.00	827,020.00	98.16
2105	Нормативт зардал	1,825,501,900.00	1,462,687,769.05	362,814,130.95	80.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,500,331,700.00	1,259,107,614.05	241,224,085.95	83.92
210502	Хоол, хүнс	255,250,200.00	189,668,155.00	65,582,045.00	74.31
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	69,920,000.00	13,912,000.00	56,008,000.00	19.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	599,462,000.00	58,662,150.00	540,799,850.00	9.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	515,512,000.00	8,173,000.00	507,339,000.00	1.59
210602	Тавилга	29,450,000.00	-	29,450,000.00	0.00
210604	Урсгал засвар	54,500,000.00	50,489,150.00	4,010,850.00	92.64
2107	Томилолт, зочны зардал	8,724,000.00	6,515,800.00	2,208,200.00	74.69
210702	Дотоод албан томилолт	8,724,000.00	6,515,800.00	2,208,200.00	74.69
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	308,650,300.00	279,614,387.00	29,035,913.00	90.59

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	275,271,000.00	269,407,750.00	5,863,250.00	97.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-	720,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,243,000.00	-	3,243,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,790,600.00	1,466,588.00	324,012.00	81.90
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	363,000.00	-	363,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,844,000.00	5,357,000.00	487,000.00	91.67
210807	Газрын төлбөр	968,700.00	928,049.00	40,651.00	95.80
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,450,000.00	2,455,000.00	17,995,000.00	12.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00	4,925,000.00	1,575,000.00	75.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	4,925,000.00	1,575,000.00	75.77
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,500,000.00	4,925,000.00	1,575,000.00	75.77
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	141,078,900.00	(141,078,900.00)	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	141,078,900.00	(141,078,900.00)	0.00
223001	Бусад хөрөнгө	-	141,078,900.00	(141,078,900.00)	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,278,964,400.00	7,194,776,430.51	1,084,187,969.49	86.90
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,555,224,800.00	7,015,884,640.00	539,340,160.00	92.86
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,555,224,800.00	7,015,884,640.00	539,340,160.00	92.86
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	723,739,600.00	178,891,790.51	544,847,809.49	24.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	706,379,400.00	172,974,690.51	533,404,709.49	24.49
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,610,000.00	5,917,100.00	9,692,900.00	37.91
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,750,200.00	-	1,750,200.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,006,760.09	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	201.00	201.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	136.00	142.00	6.00	104.41
620003	Үйлчлэх ажилтан	64.00	58.00	-6.00	90.63
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	201.00	201.00	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	144.00	143.00	1.00	99.31
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	57.00	58.00	-1.00	101.75

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн /цаашид Нэгдсэн эмнэлэг гэх/ нь “Үйлчлүүлэгчдэд ээлтэй, тэгш хүртээмжтэй тусламж үйлчилгээг хүргэж, хүн амын эрүүл мэндийг сайжруулж, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ;
- Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж;
- Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;
- Өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;
- Өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Монгол улсын засгийн газрын 2023 оны 06 сарын 21 өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.*
- 2023 оны 07 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 8 дугаар тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”,
- 2023 оны 11 сарын 17-ны өдрийн ЭМДҮЗ-ийн 10 дугаар тогтоолоор “Багц төлбөрийн хэмжээ”-ний журам баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 175 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ыг мөрдөн ажиллаж байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 6,430,023.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,488,318.8 мянган төгрөгөөр буюу 30.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,750.2	1,006.7	-743.5
Авлага		301,744.5	301,744.5
Бараа материал	494,694.0	445,728.0	-48,965.9
Үндсэн хөрөнгө	4,445,260.6	5,683,069.1	1,237,808.5
Нийт хөрөнгө	4,941,704.8	6,431,548.4	1,489,843.6
Өр төлбөр	366,589.6	667,124.0	300,534.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,575,115.2	5,764,424.4	1,189,309.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	4,941,704.8	6,431,548.4	1,489,843.6

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлага дансанд ЭМДС-аас авах санхүүжилтийн 301,744.5 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 445,728.0 мянган төгрөг болж 48,965.9 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс 48,965.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,683,069.1 мянган төгрөг болж 1,237,808.5 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамнаас 1,113,411.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 256 ширхэг үндсэн хөрөнгийг 232,479.4 мянган төгрөгөөр дахин үнэлж үнэ төлбөргүй орлогоор тус тус бүртгэснээс голлон шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 667,124.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь тайлант онд үзүүлсэн эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-аас дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-ийн санхүүжилтээс 8,431,266.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 39,434.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,393.0 мянган төгрөг зэрэг нийт **8,472,093.2** мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 193,128.8 мянган төгрөгийн орлогыг бууруулан тооцож ЭМДС-аас олгох санхүүжилтийг 7,555,224.8 мянган төгрөгөөр,

үндсэн үйл ажиллагааны орлогыг 706,379.4 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлогыг 15,610.0 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 1,750.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн нийт **8,278,964.4** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Тус Нэгдсэн эмнэлгийн 2023 оны төсвийн төслийг ЭМГ-аас хянан баталгаажуулахдаа 706,379.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд хамтын төлбөрөөс чөлөөлөгдөх үйлчлүүлэгчдийг тооцолгүйгээр хэт өндрөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 172,974.7 мянган төгрөг төвлөрч, 533,404.7 мянган төгрөгөөр тасарсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **8,278,964.4** мянган төгрөгийн төсөв баталж, ЭМДС-аас 7,015,884.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 140,342.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 38,549.5 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 743.5 мянган төгрөг нийт **7,195,519.8** мянган төгрөгийн орлого эх үүсвэрийг төвлөрүүлж урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,195,519.8 мянган төгрөг буюу 86.5 хувьтай байгаа нь орлогын төлөвлөгөө 781,700.1 мянган төгрөгөөр тасарч, ЭМДС-аас 301,744.5 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага тайлагнагдаж, нийт орлого эх үүсвэр 1,083,444.6 мянган төгрөгөөр дутагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	8,272,464.4	7,190,594.8	1,081,896.6	86.8
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/	6,500.0	4,925.0	1,572.0	75.7
	Дүн	8,278,964.4	7,195,519.8	1,083,444.6	86.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

/мянган төгрөг/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах	1,500,331.7	1,500,331.7	НТШ
2	Түргэн тусламжийн автомашины шатахуун, тослох материал нийлүүлэх	82,798.6	82,798.6	НТШ
3	Хоол хүнсний материал нийлүүлэх	255,250.2	189,668.1	НТШ
	Нийт дүн	1,838,380.5	1,772,798.4	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулан, шалгарсан дараах аж ахуйн нэгжүүдтэй бараа материал нийлүүлэх гэрээг байгуулан ажилласан байна.

Дархан Монос, Их шүүдэргэнэ, Ази фарм, Булган монос фарм, МЭИК, Цомбо, Азын нахиа, Айвико хэлт Кэйр, Мэдикал Ресурс ХХК болон Цус сэлбэн судлах төвтэй эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ, Шунхлай ХХК-ийн Зүүнхараа дахь салбараас шатахуун, тослох материал худалдан авах гэрээ, Уужим Хараа, Ноцох дөл, Галт охь, Их наран булаг ХХК-аас хүнс, хангамжийн материал нийлүүлэх гэрээг тус тус байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Эм эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс ерөнхий нэршлийн 28 төрлийн 255.997.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн НБББББ-ийг шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглагдаж байгаа хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгах зэрэг 3 зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,710,309.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 100,654.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын Нэгдсэн эмнэлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг хэмнэх зорилгоор цахилгаан, дулааны тоолуурыг шинэчилсэн,*
- *Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд, бусад арга хэмжээнүүдтэй холбогдуулан контент, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нэгдсэн эмнэлгийн мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2

дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, холбогдох албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр ээлжийн амралтын цалинг давхардуулан олгосон зэрэг 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, өндөр өртөгтэй үйлчилгээний санхүүжилтийн үр дүнг тооцож, гэрээг дүгнэлгүйгээр олгосон, худалдан авалтын явцад үнийн маргаан үүсгэсэн нийлүүлэгчид эвлэрлийн гэрээний дагуу хохирол нөхөн төлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зэрэг 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	4,820.7	2	4,820.7	100
Зөвлөмж	2	3,000.0	2	3,000.0	100
Нийт дүн	4	7,820.7	4	7,820.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус эмнэлэг нь дараа оны төсвийн төслийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөхдөө хамтын төлбөрөөс чөлөөлөгдөх орлогыг өөрийн орлогын төлөвлөгөөнөөс хасаж тооцон бодитоор төлөвлөх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 119,903.2 мянган төгрөгийн алдаа¹ алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тогтоогүйгээс элэгдлийн зардлыг 2,477.8 мянган төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан,

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.35 дахь “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Дт. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, Кт. Хуримтлагдсан элэгдэл” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Санхүүгийн байдлын тайлангаас эд хариуцагчийн бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл нь 34,435.5 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдэл нь 71,332.7 мянган төгрөгөөр зэрэг нийт 105768.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан,

3. Сэлбэг хэрэгслийн дансанд эмнэлгийн хэрэгсэл болох чагнуур, даралтын аппарат зэрэг 5,859.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэж тайлагнасан байна.

4. Мандал сум дахь ШШГХ 413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид 4,597.3 мянган төгрөгийн сүрьеэгийн шинжилгээний болон эмчилгээний эм, эмнэлгийн хэрэгслийг үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн боловч бүртгэл тайланд өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

5. Үнэ төлбөргүй ирсэн бараа материалын орлогыг 1,200.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх “Үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 9,465.5 мянган төгрөгийн зөрчил² илэрч 6,965.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,500.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх 2 зөрчилд зөвлөмж өгөв.


5.1 Төлбөрийн акт

1. Кассын бэлэн мөнгөний орлогын тайлан, тооцоог тухай бүр хянаж баталгаажуулаагүйгээс хэвтэн эмчлүүлэгчдээс төвлөрсөн хамтын төлбөрийн 6,965.5 мянган төгрөгийн орлогыг байгууллагын дансанд дутуу төвлөрүүлж, тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1: жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.5: бүх орлого” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас санхүүжүүлэх дулааны шугам гагнуулсны 2,500.0 мянган төгрөгийн ажлын хөлсийг цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаа эрүүл мэндийн байгууллагын онцлогт нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 -т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ..., мөрдөж ажиллана.” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

5.3.1 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 358 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэх саналыг бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлж шивэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ

байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Элэгдлийн зардлыг дутуу тооцож тайлагнасан	1	2,477.8	1	2,477.8			1	2,477.8				
Эд хариуцагчийн тайлангийн эхний үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнагдсан	1	105,768.2			1	105,768.2	1	105,768.2				
Бараа материалыг буруу ангилж бүртгэсэн	1	5,859.9			1	5,859.9	1	5,859.9				
Үнэ төлбөргүйгээр шилжүүлэн олгосон эмийг өглөгөөр бүртгэж тайлагнасан	1	4,597.3			1	4,597.3	1	4,597.3				
Үнэ төлбөргүй ирсэн бараа материалын орлогыг дутуу тайлагнасан.	1	1,200.0	1	1,200.0			1	1,200.0				
Дүн	5	119,903.2	2	3,677.8	3	116,225.4	5	119,903.2				

/мянган төгрөгөөр/

431747908
МОНГОЛ 65

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн МНО асуудал	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Кассын орлогыг дууу төвлөрүүлсэн	1	6,965.5	1	6,965.5				
Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй	1	2,500.0	1	2,500.0				
НБББББ нь хууль тогтоомж, бүртгэлийн стандарт, үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.	1							
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг дахин үнэлээгүй	1							
Дүн	4	9,465.5	1	6,965.5	1	2,500.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						